



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 4/2021

Мандалговь

“Спэйшлтим ап” ХХК-тай гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн А/57 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сайнцагаан сумын Далай хорооллын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Спэйшлтим ап” ХХК-тай 229,757,378 (хоёр зуун хорин есөн сая долоон зуун тавин долоон мянга гурван зуун далан найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу Сайнцагаан сумын Далай хорооллын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Спэйшлтим ап” ХХК-ний захирал (Х.Анхболд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАН



468210389